



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 8 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХЭА-2022/154/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чингис хот 2022 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Эрдэнэбаатар
	Утас:	70562112
	Аудитын менежер:	Д.Оюунтуяа
	Утас:	99775390
	“Өндөрхаан итгэл аудит” ХХК-ийн:	
	Аудитор:	Б.Маналсүрэн
	Утас:	99059424

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	4
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	4
3. Аудитын тайлан .....	5
3.1 Ерөнхий зүйл .....	5
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	5
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	5
3.4 Материаллаг байдал .....	6
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	6
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	7
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	8
3.8 Аудитын гол асуудал .....	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	8
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	8
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	8
4. Аудитын илрүүлэлт .....	9
4.1 Залруулсан алдаа .....	9
4.2 Төлбөрийн акт .....	9
4.3 Албан шаардлага .....	9
4.4 Зөвлөмж .....	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	10

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

дод 203.23 № 306

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Хүүхдийн наймдугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Хүүхдийн наймдугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

023033567

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

---

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

---

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэг

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгсгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>52,286,850.00</b>	<b>66,267,644.00</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
33	<b>АВЛАГА</b>	-	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
335	<b>Бусад авлага</b>	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	-
3471	<b>Урьдчилгаа тооцоо</b>	-	-
34713	Цалингийн урьдчилгаа	-	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	52,286,850.00	66,267,644.00
351	<b>Түүхий эд материал</b>	526,750.00	753,560.00
35110	Тусгай зориулалттай материал	113,600.00	113,600.00
35130	Эм боох материал	413,150.00	639,960.00
354	<b>Хангамжийн материал</b>	51,760,100.00	65,514,084.00
35410	Бичиг хэргийн материал	219,000.00	80,000.00
35420	Аж ахуйн материал	2,358,370.00	2,697,200.00
35440	Түлш, шатах тослох материал	290,000.00	240,000.00
35450	Барилгын засварын материал	80,000.00	80,000.00
35460	Хүнсний материал	2,191,186.00	3,985,090.00
35470	Бусад хангамжийн материал	46,621,544.00	58,431,794.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,116,452,290.23</b>	<b>1,089,682,344.05</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,116,452,290.23	1,089,682,344.05
392	<b>Биет хөрөнгө</b>	1,040,420,290.23	1,013,650,344.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	997,595,998.43	997,595,998.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,645,494.16)	(36,894,260.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,050,292.55	65,000,272.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,464,805.86)	(40,474,659.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,502,922.40	29,002,922.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,856,066.25)	(17,002,880.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,664,000.00	26,968,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,937,875.42)	(13,056,367.23)
39217	Ном	2,511,318.54	2,511,318.54
393	<b>Биет бус хөрөнгө</b>	76,032,000.00	76,032,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	76,032,000.00	76,032,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,168,739,140.23</b>	<b>1,155,949,988.05</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,277,928.00</b>	-
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,277,928.00	-
413	<b>Өглөг</b>	1,277,928.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	1,277,928.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,277,928.00	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,167,461,212.23</b>	<b>1,155,949,988.05</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,167,461,212.23	1,155,949,988.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	491,219,892.25	491,219,892.25
51101	Өмч: - төрийн	491,219,892.25	491,219,892.25
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	655,855,896.25	644,344,672.07
51210	Өмнөх үеийн үр дүн	655,855,896.25	655,855,896.25
51220	Тайланг үеийн үр дүн	-	(11,511,224.18)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,385,423.73	20,385,423.73
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,168,739,140.23</b>	<b>1,155,949,988.05</b>

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэг

## АУДИТ ХЙИГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,013,276,782.00</b>	<b>372,086,330.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>653,088,382.00</b>	<b>7,780,430.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	653,088,382.00	7,780,430.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	653,088,382.00	7,780,430.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	653,088,382.00	7,780,430.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>360,188,400.00</b>	<b>364,305,900.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	334,577,200.00	323,387,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	334,577,200.00	323,387,300.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	87,500.00	747,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	657,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	87,500.00	89,200.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	25,523,700.00	40,171,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,523,700.00	40,171,600.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>344,215,829.78</b>	<b>383,597,554.18</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>344,215,829.78</b>	<b>383,597,554.18</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	307,858,013.78	353,539,082.68
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	215,608,608.00	231,808,709.00
210101	Үндсэн цалин	152,480,711.00	173,341,202.00
210102	Нэмэгдэл	49,223,797.00	38,598,493.00
210104	Урамшуулал	13,904,100.00	19,869,014.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,177,518.00	31,334,555.00
210201	Тэтгэврийн даатгал	18,602,647.00	21,820,757.16
210202	Тэтгэмжийн даатгал	2,143,718.00	2,425,699.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,714,974.00	1,890,159.36
210204	Ажилгүйдлийн даатгал	428,743.00	472,540.10
210205	Эрүүл мэндийн даатгал	4,287,436.00	4,725,398.92
2103	<b>Байр аниглалттай холбоотой төгтмөл зардал</b>	25,316,428.00	34,210,110.00
210301	Гэрэл, цахилгаан	4,123,256.00	3,638,822.00
210302	Тулш, халаалт	18,122,412.00	25,924,008.00
210303	Цэвэр, бохир ус	3,070,760.00	4,647,280.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,541,931.00	6,730,517.50
210401	Бичиг хэрэг	466,540.00	294,000.00
210402	Тээвэр, шатахуун	809,810.00	542,450.00
210403	Шуудан, холбоо, нинтернэтийн төлбөр	726,111.00	892,847.50
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	509,000.00	697,400.00
210406	Бага үнэтэй, гүргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,391,570.00	3,099,970.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал	638,900.00	1,203,850.00
2105	<b>Нормативт зардал</b>	13,450,913.00	8,530,065.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	147,050.00	526,327.00
210502	Хоол, хүнс	13,303,863.00	8,003,738.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	-	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,354,400.00	1,801,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210604	Урсгал засвар	1,354,400.00	1,801,200.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	93,500.00	207,000.00
210702	Дотоод албан томилолт	93,500.00	207,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	90,000.00	432,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	90,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	432,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20,224,715.78	38,484,926.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	135,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,502,600.00	2,826,000.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,722,115.78	35,523,926.18
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	36,357,816.00	30,058,471.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,623,802.00	4,954,090.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,623,802.00	4,954,090.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	89,800.00	1,766,212.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,800.00	1,747,012.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	19,200.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,644,214.00	23,338,169.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,644,214.00	23,338,169.50
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>669,060,952.22</b>	<b>(11,511,224.18)</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	167,488.44	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	167,488.44	-
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(167,488.44)	-
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>668,893,463.78</b>	<b>(11,511,224.18)</b>

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэг

## АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	491,219,892.25	20,385,423.73	(13,037,567.53)	498,567,748.45
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	491,219,892.25	20,385,423.73	(13,037,567.53)	498,567,748.45
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	668,893,463.78	668,893,463.78
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	491,219,892.25	20,385,423.73	655,855,896.25	1,167,461,212.23
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	491,219,892.25	20,385,423.73	655,855,896.25	1,167,461,212.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	491,219,892.25	20,385,423.73	655,855,896.25	1,167,461,212.23
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүдэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(11,511,224.18)	(11,511,224.18)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	491,219,892.25	20,385,423.73	644,344,672.07	1,155,949,988.05

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэг

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>360,188,400.00</b>	<b>364,305,900.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>360,188,400.00</b>	<b>364,305,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>334,577,200.00</b>	<b>323,387,300.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	334,577,200.00	323,387,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>87,500.00</b>	<b>747,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	657,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	87,500.00	89,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>25,523,700.00</b>	<b>40,171,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,523,700.00	40,171,600.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>337,741,470.00</b>	<b>355,551,920.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>337,741,470.00</b>	<b>355,551,920.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>302,413,356.00</b>	<b>325,548,638.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>215,299,256.00</b>	<b>231,808,709.00</b>
210101	Үндсэн цалин	152,480,711.00	173,341,202.00
210102	Нэмэгдэл	48,914,445.00	38,598,493.00
210104	Урамшуулал	13,904,100.00	19,869,014.00
210105	Гэрээт ажлын хөлс		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,177,518.00</b>	<b>31,334,555.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,602,647.00	21,820,757.16
210202	Тэтгэмжийн даатгал	2,143,718.00	2,425,699.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,714,974.00	1,890,159.36
210204	Ажилгүйдлийн даатгал	428,743.00	472,540.10
210205	Эрүүл мэндийн даатгал	4,287,436.00	4,725,398.92
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24,038,500.00</b>	<b>35,488,038.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,123,256.00	3,638,822.00
210302	Түлш, халаалт	16,844,484.00	27,201,936.00
210303	Цэвэр, бохир ус	3,070,760.00	4,647,280.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,400,753.00</b>	<b>7,486,567.50</b>
210401	Бичиг хэрэг	1,569,932.00	304,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,099,810.00	492,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	728,611.00	969,847.50
210404	Ном, хэвлэл	25,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	846,400.00
210406	Бага үнэгэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,437,400.00	4,873,870.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>18,935,821.00</b>	<b>11,836,921.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	472,650.00	741,137.00
210502	Хоол, хүнс	14,477,671.00	9,767,784.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,985,500.00	1,328,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,697,898.00</b>	<b>3,238,248.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	219,998.00	31,698.00
210602	Тавилга	82,500.00	-
210604	Урсгал засвар	1,395,400.00	3,206,550.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>93,500.00</b>	<b>207,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	93,500.00	207,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>87,500.00</b>	<b>432,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,500.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	432,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,682,610.00</b>	<b>3,716,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	135,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,682,610.00	3,581,600.00

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35,328,114.00</b>	<b>30,003,281.50</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,594,100.00	4,898,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,594,100.00	4,898,900.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	89,800.00	1,766,212.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,800.00	1,747,012.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	19,200.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	32,644,214.00	23,338,169.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,644,214.00	23,338,169.50
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>22,446,930.00</b>	<b>8,753,980.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>22,446,930.00</b>	<b>8,753,980.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>22,446,930.00</b>	<b>8,753,980.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	22,446,930.00	8,753,980.00
223001	Бусад хөрөнгө	22,446,930.00	8,753,980.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(22,446,930.00)</b>	<b>(8,753,980.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэг

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	363,558,900.00	338,473,718.50
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	363,558,900.00	338,473,718.50
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	358,658,900.00	333,574,818.50
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	240,782,700.00	231,808,709.00
210101	Үндсэн цалин	173,121,100.00	173,341,202.00
210102	Нэмэгдэл	46,531,600.00	38,598,493.00
210104	Урамшуулал	21,130,000.00	19,869,014.00
210105	Гэрээг ажлын хөлс		
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,190,400.00	31,334,555.00
210201	Тэтгэврийн даатгал	23,939,900.00	21,820,757.16
210202	Тэтгэмжийн даатгал	2,562,600.00	2,425,699.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,050,100.00	1,890,159.36
210204	Ажил үйлдлийн даатгал	512,500.00	472,540.10
210205	Эрүүл мэндийн даатгал	5,125,300.00	4,725,398.92
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	37,186,400.00	35,488,038.00
210301	Гэрэл, цахилгаан	5,564,600.00	3,638,822.00
210302	Түлш, халаалт	24,821,800.00	27,201,936.00
210303	Цэвэр, бохир ус	6,800,000.00	4,647,280.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,155,500.00	7,028,767.50
210401	Бичиг хэрэг	280,500.00	304,000.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	492,450.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	1,074,100.00	969,847.50
210404	Ном, хэвлэл	55,900.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	695,000.00	688,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,550,000.00	4,573,870.00
2105	<b>Нормативт зардал</b>	23,198,400.00	11,836,921.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	750,000.00	741,137.00
210502	Хоол, хүнс	20,698,400.00	9,767,784.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	1,750,000.00	1,328,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,789,200.00	11,722,228.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,500,000.00	3,481,678.00
210602	Тавилга	5,304,000.00	5,304,000.00
210604	Урсгал засвар	2,985,200.00	2,936,550.00
2107	<b>Томилголт, зочны зардал</b>	207,000.00	207,000.00
210702	Дотоод албан томилголт	207,000.00	207,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	432,000.00	432,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,717,300.00	3,716,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	135,700.00	135,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,581,600.00	3,581,600.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4,900,000.00	4,898,900.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,900,000.00	4,898,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,900,000.00	4,898,900.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
223001	Бусад хөрөнгө	-	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	363,558,900.00	338,473,718.50
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	323,387,300.00	300,049,130.50
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	323,387,300.00	300,049,130.50
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	40,171,600.00	38,424,588.00
132001	Орон нутгийн төсвөөс	40,171,600.00	38,424,588.00

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэг

## АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>747,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>747,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	727,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	457,800.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	157,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	300,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	270,000.00
210604	Урсгал засвар	-	270,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		19,200.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>		19,200.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг		19,200.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>747,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	747,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	657,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	89,200.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын наймдугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн аудитор О.Энхтунгалаг, аудиторын туслах М.Мөнхзаяа нар гүйцэтгэж, хяналтыг компанийн захирал, аудитор Б.Маналсүрэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын наймдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өндөрхаан итгэл аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хэрлэн сумын наймдугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулиар дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын наймдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 344,383.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,443.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,755.1 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Хэрлэн сумын наймдугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,789.1 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	-		-
Урьдчилгаа			-
Бараа материал	52,286.70	66,267.60	13,980.90
Үндсэн хөрөнгө	1,116,452.40	1,089,682.40	(26,770.00)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,168,739.10</b>	<b>1,155,950.00</b>	<b>(12,789.10)</b>
Өр төлбөр	1,277.90		(1,277.90)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,167,461.20	1,155,950.00	(11,511.20)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	491,219.90	491,219.90	-
Хуримтлагдсан үр дүн	655,855.90	655,855.90	-
Тайлант үеийн үр дүн		(11,511.20)	(11,511.20)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,385.40	20,385.40	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,168,739.10</b>	<b>1,155,950.00</b>	<b>(12,789.10)</b>

Өглөгийн дансны үлдэгдэл 1,277.9 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 66,267.6 мянган төгрөг болж 13,980.9 мянган төгрөгөөр өссөн нь хүнсний материал, бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,089,682.4 мянган төгрөг болж 26,770.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан 35,523.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 644,344.7 мянган төгрөг болж, 11,511.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгийн бууралт нөлөөлсөн байна.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын наймдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 641,190.5 мянган төгрөгөөр буюу 63.3 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 645,308.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 39,381.7 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлуудыг авч үзвэл бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал 1,708.4 мянган төгрөг, түлш халаалтын зардал 7,801.6 мянган төгрөгөөр өссөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 478,395.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 114,836.3 мянган төгрөгөөр бууруулан 363,558.9 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: хоол хүнсний зардлыг 49,839.1 мянга, түлш халаалтын зардлыг 2,203.3 мянга, цалингийн зардлыг 38564.4 мянган төгрөгөөр бууруулж, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлыг 4,437.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 363,558.9 мянган төгрөгөөр баталсанаас 323,387.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 40,171.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 323,387.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 40,171.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 338,473.7 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 23,338.2 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 1,747.0 мянган төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 338,473.7 мянган төгрөг буюу 93.1 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 8,974.0 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 10,930.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 657.8 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 89.2 мянга, нийт 747.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн зарцуулж, 19.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны сайтад оруулбал зохих 144 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

**ХЭА-2022/154/НА-СТА-ТШЗ**

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 5,776.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,898.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 878.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

##### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

##### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

##### **4.3 Албан шаардлага**

4.3.1 Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас ажиллагсадад 4,898.9 мянган төгрөгийн шагнал урамшуулал, түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон нь ЗГ-ын 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

##### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал.**

Илрүүлэлт:

4.4.1. Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 878.0 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтууд, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид цахим төлбөрийн баримтгүй худалдан авалт хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
	Хэрлэн сумын 8 дугаар Цэцэрлэг	2	5,776.9					1	4,898.9	1	878.0
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>5,776.9</b>					<b>1</b>	<b>4,898.9</b>	<b>1</b>	<b>878.0</b>



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 206/23910610  
ХЭА 2022/154/НА СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын наймдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас ажиллагсадад 4,898,9 мянган төгрөгийн шагнал урамшуулал, түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-д "Шагнал урамшуулал олгохгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох журам, зааврыг хэрэгжүүлж ажилладаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын наймдугаар цэцэрлэгийн эрхлэгч Д.Нэргүй, нягтлан бодогч Н.Энхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Б.МАНАЛСҮРЭН

Д.ОЮУНТУЯА

